

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2-3
2	Аудитын тайлан	
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10-10
3	Менежментийн захидал.....	11-13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15-16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20-21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БСШУСЯ	Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яам
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗАХИРАЛ Ж.АРИУНБОЛД ТАНАА

2019.03.07 № 06/402
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус зөвлөлийн ажлын албаны захирал Ж.Ариунболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн шилэн данс, нягтлан бодох бүртгэлийн тайлагнал, санхүүгийн тайлангийн иж бүрдэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 18-наас 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн аудитор Ж.Үхэртар хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь Сургалтын чанарыг дэмжиж, дээд, мэргэжлийн боловсролын байгууллага, хөтөлбөрийн үндэсний стандартыг сахиулж, олон улсын хэмжээнд боловсролын үнэлэмж, байр суурийг бэхжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 240 дүгээр тогтоолоор Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Боловсролын байгууллагын магадлан итгэмжлэл
- ✓ Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл
- ✓ Шинээр нээх сургалтын хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 281 тоот тогтоолоор Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчилсэн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2014 оны 10 сарын 01-нд баталсан дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Үндэсний зөвлөл нь хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн хэм хэмжээг хангасан санхүүгийн журамтай байна” гэж заасан ч санхүүгийн журмыг батлаагүй байна.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашигладаггүй байна.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад хяналтын зөвлөл нь дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллуулж чадахгүй байна гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс болон өөрийн магадлан итгэмжлэлийн орлогоос санхүүждэгтэй холбоотой юм.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны нийт орлого 861,252.7 мянган төгрөг бөгөөд 2 хувь буюу 17,225.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг Б401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	-	
2	Албан шаардлага өгсөн	1	344,674.3	
	Дүн	5	344,674.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулсан бөгөөд бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Тус зөвлөл нь батлагдсан төсөв төлөвлөгөө, хууль эрх зүйн хувьд байгууллагын статус тодорхой бус байсан бөгөөд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, БМИҮЗ-ийн ажлын албаны захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээний хавсралтаар баталсан 2018 оны төсвийн төлөвлөгөөг баримтлан шалгалт хийхэд 213,097.3 мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 557,771.6 мянган төгрөгийн орлого олж, 61.7 хувиар буюу 344,674.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Мөн 463,718.6 мянган төгрөгийн нийт төсвийн хүрээнд зардал гаргах төлөвлөгөөтэй байсан боловч гүйцэтгэлээр 769,074.8 мянган төгрөгийг зарцуулж, батлаагүй өөрийн зардлыг 65.8 хувиар буюу 305,356.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-ийн “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад баримтлах зарчим”, 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 6.6.2-т “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, мөн тус зөвлөлийн 2018 оны үр дүнгийн гэрээний хавсралтаар баталсан орлогын зарлагын төлөвлөгөө, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6-д заасан “Үндэсний зөвлөлийн төсвийг удирдах зөвлөлийн хурлаас батална” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцад дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц 3 асуудлыг тодорхойлов.

1. Ажлын албаны захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг шалгах

2. Монгол Улсын Засгийн газрын 281 дүгээр тогтоолоор батлагдсан дүрмийн хэрэгжилтийг нягталж шалгах
3. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Үндэсний зөвлөл нь хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн хэм хэмжээг хангасан санхүүгийн журамтай байна. Санхүүгийн журам нь байгууллагын үйл ажиллагааны дотоод журмын салшгүй хэсэг байна” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгах

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотойгоор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулан 20 орон тооны ажилчдын цалингийн санд зориулан 2018 онд 250,621.2 мянган төгрөгийн төсөв батлуулжээ. Гүйцэтгэлээр 99.8 хувь буюу 250,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь удирдах дээд шатны байгууллагаар төсвөө батлуулдаггүй, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэдэггүй зөвхөн тус зөвлөлийн ажлын албаны захирал болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хавсралтаар өөрийн үйл ажиллагааны орлого зарлагыг батлуулдаг. Тус үр дүнгийн гэрээнд өөрийн үйл ажиллагааны орлогыг 213,097.3 мянган төгрөгөөр төлөвлөн батлуулж үүнийгээ үйл ажиллагаандаа зарцуулна гэж тусгасан ч гүйцэтгэлээр 557,771.6 мянган төгрөгийг олж 519,074.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан орлогын төлөвлөгөөг 344,674.3 төгрөгөөр давуулан биелүүлсэн байгаа нь орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, удирдах зөвлөлөөр батлуулаагүйтэй холбоотой.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус зөвлөл нь <http://shilendans.gov.mn> хаягт 2018 оны эхний хагас жилийн тайлан мэдээг оруулсан ба сүүлийн хагас жилийн мэдээг шивж оруулаагүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь 2017 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчны талаар:

3.1.1 Илрүүлэлт:

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь хууль эрх зүйн хувьд статус тодорхой бус байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллагаар бүртгэлтэй байгаа бөгөөд 2016 онд батлагдсан Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т “боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон, ашгийн төлөө бус байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагааныхаа үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана”, 39 дүгээр зүйлийн 39.14-т “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг үр дүн гүйцэтгэлд суурилан гэрээний дагуу улсын төсвөөс зардлын тодорхой хувийг санхүүжүүлэх бөгөөд үйлчилгээний төлбөрийн хэмжээг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөл тогтооно” гэж заасанаас үзэхэд тус зөвлөлийг төсвийн шууд захирагчтай гэж үзэх үндэслэл хангалтгүй байна. Мөн тус зөвлөл нь төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж тайлагнадаггүй, төрийн санд дансгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна”, 7 дугаар зүйлийн 7.4-т “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана”, 8 дугаар зүйлийн 8.9.1-т

“төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хяналт тавих боломжгүй болох

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын хууль эрх зүйн үндэслэлийг сайжруулж, холбогдох дүрэм журманд өөрчлөлт оруулж статусаа тодорхой болгох

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлж ажиллана.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.2.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэдэггүй ба санхүүгийн тайлангийн иж бүрэн байдлыг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь аудитын толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Мөн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн бүрдэл хангалтгүйгээс алдаа зөрчлийг илрүүлэх боломжийг бууруулах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг холбогдох хууль, журам, стандартын дагуу бэлтгэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Дотоод аудит

3.3.1 Илрүүлэлт:

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн хяналтын зөвлөл нь 2017 оны үйл ажиллагаанд шалгалт хийсэн бөгөөд тус шалгалтаар магадлан итгэмжлэлийн үйл явц, гүйцэтгэлд шалгалт хийж, санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгээгүй байна. Мөн 2018 онд хяналтын зөвлөл ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод

аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Боловсролын магадлан итгэмжлэх зөвлөлийн дүрмийн 9.1, 9.3-т заасан бүрэн эрхийг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө зориулалт бус зүйлд зарцуулагдах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хяналтын зөвлөлийг бүрэн эрхийн хүрээнд нь ажиллуулж, дотоод хяналтыг сайжруулах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлж ажиллана.

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.4.1 Илрүүлэлт:

Тус зөвлөл нь <http://shilendans.gov.mn/> хаягаар 2018 оны сүүлийн хагас жилийн мэдээг шивж оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2-т заасан заалтуудыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг хянах боломжгүй болох

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн шивж оруулах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/			
Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89 670 121,21	128 565 681,80
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	89 670 121,21	128 366 897,33
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	89 670 121,21	128 366 897,33
4	Төгрөг	36 474 569,23	91 501 573,67
5	Гадаад валют	53 195 551,98	36 865 323,66
6	Арилжааны банк дахь харилцах	53 195 551,98	36 865 323,66
7	АВЛАГА	-	198 784,47
8	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	198 784,47
9	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	49 703 056,48	55 595 040,78
10	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	49 703 056,48	55 595 040,78
11	Биет хөрөнгө	49 703 056,48	55 595 040,78
12	Машин, тоног төхөөрөмж	27 090 277,00	27 090 277,00
13	Хуримтлагдсан элэгдэл	-19 565 200,00	-22 274 227,70
14	Тавилга, аж ахуйн эд хогшил	60 586 044,00	81 705 864,00
15	Хуримтлагдсан элэгдэл	-18 408 064,52	-30 926 872,52
16	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	139 373 177,69	184 160 722,58
17	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1 253 512,57	10 521 445,44
18	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1 253 512,57	10 521 445,44
19	Өглөг	1 253 512,57	10 521 445,44
20	Бусад өглөг	1 253 512,57	10 521 445,44
21	Байгууллагад төлөх өглөг	1 253 512,57	10 521 445,44
22	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	138 119 665,12	173 639 277,14
23	Засгийн газрын хувь оролцоо	138 119 665,12	173 639 277,14
24	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн	42 480 772,28	42 480 772,28
25	Өмч: -Төрийн өмч	42 480 772,28	42 480 772,28
26	Хуримтлагдсан үр дүн	95 638 892,84	131 158 504,86
27	Өмнөх үеийн үр дүн	90 127 177,59	95 638 892,84
28	Тайлант үеийн үр дүн	5 511 715,25	35 519 612,02
29	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	139 373 177,69	184 160 722,58

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	444 370 240,52	807 771 626,20
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	295 070 240,52	557 771 626,20
3	Нийтлэг татварын бус орлого	295 070 240,52	557 771 626,20
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	295 070 240,52	557 771 626,20
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	226 004 086,72	353 070 052,38
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19 800 000	156 969 027,82
7	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	49 266 153,80	47 732 546,00
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	149 300 000,00	250 000 000,00
9	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	149 300 000,00	250 000 000,00
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	438 858 525,27	769 074 850,08
11	УРСГАЛ ЗАРДАЛ	438 858 525,27	769 074 850,08
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438 858 525,27	769 074 850,08
13	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	133 543 414,20	258 667 960,77
14	Цалин	116 164 619,20	223 785 833,77
15	Унаа хоолны хөнгөлөлт	17 378 795,00	34 882 127,00
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт	14 689 775,55	31 040 155,29
17	Тэтгэврийн даатгалын шимтгэл	9 348 038,99	20 693 436,86
18	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1 068 347,31	2 586 679,60
19	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2 670 868,28	5 173 359,22
20	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1 335 434,14	517 335,92
21	Эрүүл мэндийн даатгалын хураамж	267 086,83	2 069 343,69
22	Хангамж, бараа материалын зардал	30 983 781,00	40 049 593,50
23	Бичиг хэргийн материал	3 964 397,00	5 199 821,00
24	Тээвэр, шатахууны зардал	5 366 065,00	4 829 970,00
25	Шуудан холбоо интернетийн төлбөр	5 565 129,00	6 801 063,22
26	Ном хэвлэлийн зардал		4 720 334,06
27	Хог хаягдал устгах, цэвэрлэх		265 374,00
28	Аж ахуйн материал худалдан авах зардал	16 088 190,00	18 233 031,22
29	Эд хогшил, урсгал засварын зардал	-	17 890 000,00
30	Тавилга	-	17 890 000,00
31	Томилолт , зочны зардал	-	28 969 484,60
32	Гадаад албан томилолт	-	27 673 684,60
33	Дотоод албан томилолт	-	1 295 800,00
34	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236 701 370,39	377 229 820,22
35	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил	236 701 370,39	377 229 820,22
36	Бараа үйлчилгээний бусад зардал	22 940 184,13	15 227 835,70
37	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22 940 184,13	15 227 835,70
38	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	5 511 715,25	38 696 776,12
39	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3 177 164,10
40	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3 177 164,10
41	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	-3 177 164,10
42	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	5 511 715,25	35 519 612,02

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	444 370 240,50	807 771 626.20
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	295 070 240,50	557 771 626.20
3	Нийтлэг татварын бус орлого	295 070 240,50	557 771 626.20
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	295 070 240,50	557 771 626.20
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	226 004 100,70	353 070 052,38
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19 800 000,00	156 969 027.82
7	Гадаадын эх үүсвэрээр санхүүжих	49 266 139,80	47 732 546.00
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	149 300 000,00	250 000 000,00
9	Төсвийн захирагчдаас	149 300 000,00	250 000 000,00
10	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	149 300 000,00	250 000 000,00
11	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	422 830 335,25	751 184 850.08
12	УРСГАЛ ЗАРДАЛ	422 830 335,25	751 184 850.08
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422 830 335,25	751 184 850.08
14	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	133 543 414,20	258 667 960,77
15	Цалин	116 164 619,20	223 785 833,77
16	Унаа хоолны хөнгөлөлт	17 197 200,00	34 882 127,00
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14 689 775,50	55 136 561,00
18	Тэтгэврийн даатгалын шимтгэл	9 348 039,00	38 355 868,52
19	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1 068 347,30	4 315 035,21
20	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2 670 868,30	9 588 967,13
21	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1 335 434,10	958 896,71
22	Эрүүл мэндийн даатгал	267 086,80	1 917 793,43
23	Хангамж, бараа материалын зардал	30 983 781,00	40 049 593,50
24	Бичиг хэргийн материал	3 964 397,00	5 199 821,00
25	Тээвэр, шатахууны зардал	5 366 065,00	4 829 970,00
26	Шуудан холбоо интернетийн төлбөр	5 565 129,00	6 801 063,22
27	Ном хэвлэлийн зардал	-	4 720 334.06
28	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	265 374.00
29	Аж ахуйн материал худалдан авах зардал	16 088 190,00	18 233 031.22
30	Эд хогшил, урсгал засварын зардал	-	17 890 000,00
31	Тавилга	-	17 890 000,00
32	Томилолт, зочны зардал	-	28 969 484,60
33	Гадаад албан томилолт	-	27 673 684,60
34	Дотоод албан томилолт	-	1 295 800,00
35	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	243 613 364,55	350 471 250,21
36	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	243 613 364,55	350 471 250,21
37	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	21 539 905,25	56 586 776,12
38	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	16 028 190,00	17 890 000,00
39	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16 028 190,00	17 890 000,00
40	Дотоод эх үүсвэрээр	16 028 190,00	17 890 000,00
41	Үндсэн хөрөнгө худалдан авсан зардал		17 890 000,00

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

42	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16 028 190,00	
43	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-16 028 190,00	-17 890 000,00
44	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-16 028 190,00	-17 890 000,00
45	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5 511 715,25	38 696 776,12
46	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84 158 405,96	89 670 121,21
47	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	89 670 121,21	128 366 897,33

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	90 127 177,59	90 127 177,59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	42 480 772,28	-	42 480 772,28
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн		5 511 715,25	5 511 715,25
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	42 480 772,28	95 638 892,84	138 119 665,12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	35 519 612,02	35 519 612,02
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	42 480 772,28	131 158 504,86	173 639 277,14

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	250 621 235,00	250 000 000,00	621 235,00	99,8
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	250 621 235,00	250 000 000,00	621 235,00	99,8
Бараа, үйлчилгээний зардал	250 621 235,00	250 000 000,00	621 235,00	99,8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250 621 235,00	250 000 000,00	621 235,00	99,8
Үндсэн цалин	250 621 235,00	223 785 833,77	26 835 401,23	89,3
Унаа, болон бусад нөхөн олговор	-	26,214,616.23	-26,214,616.23	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	250 621 235,00	250 000 000,00	621 235,00	99,8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	250 621 235,00	250 000 000,00	621 235,00	99,8
Улсын төсвөөс санхүүжих	250 621 235,00	250 000 000,00	621 235,00	99,8
АЖИЛЛАГСДЫН ТОО	20	105	-	80,0
Удирдах ажилтан	1	1	-	100,0
Гүйцэтгэх ажилтан	19	15	-	78,9

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2019.02.28

Аудитын
нэр:

*Боловсролын магадлан
итгэмжлэх үндэсний зөвлөлийн
2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн*

Аудитын код:

САГ-2019/378/СТА-ТШЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл

мянган
төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулла гаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Тус зөвлөл нь хууль эрх зүйн хувьд статус тодорхой бус байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллагаар бүртгэлтэй байгаа бөгөөд 2016 онд батлагдсан Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т “боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон, ашгийн төлөө бус байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагааныхаа үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана”, 39 дүгээр зүйлийн 39.14-т “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг үр дүн гүйцэтгэлд суурилан гэрээний дагуу улсын төсвөөс зардлын тодорхой хувийг санхүүжүүлэх бөгөөд үйлчилгээний төлбөрийн хэмжээг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөл тогтооно” гэж заасанаас үзэхэд тус зөвлөлийг төсвийн шууд захирагчтай гэж үзэх үндэслэл хангалтгүй байна. Мөн төрийн санд харилцах дансгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ажлын албаны захирал, Нягтлан бодогч	Ж.Ариунболд Г.Отгон

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Тус байгууллагын хяналтын зөвлөл нь 2017 оны үйл ажиллагаанд шалгалт хийсэн бөгөөд тус шалгалтаар зөвхөн магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд шалгалт хийж, санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгээгүй байна. Мөн 2018 онд хяналтын зөвлөл бүрэн эрхийн хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ажлын албаны захирал, Нягтлан бодогч	Ж.Ариунболд Г.Отгон
3	Тус зөвлөл нь http://shilendans.gov.mn/ хаягаар 2018 оны сүүлийн хагас жилийн мэдээг шивж оруулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ажлын албаны захирал, Нягтлан бодогч	Ж.Ариунболд Г.Отгон
4	Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу бүрэн бэлтгээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ажлын албаны захирал, Нягтлан бодогч	Ж.Ариунболд Г.Отгон
5	Тус зөвлөл нь батлагдсан төсөв төлөвлөгөө тодорхой бус, хууль эрх зүйн хувьд байгууллагын статус тодорхой бус байсан тул БСШУСЯамны төсвийн ерөнхийлөн захирагч, БМИҮЗ-ийн ажлын албаны захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээний хавсралтаар баталсан 2018 оны төсвийн төлөвлөгөөг баримтлан шалгахад өөрийн үйл ажиллагаанаас 213,097.3 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 557,771.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 61.7 хувиар буюу 344,674.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Мөн 463,718.6 мянган төгрөгийн нийт төсвийн хүрээнд зардал гаргах төлөвлөгөөтэй байсан боловч гүйцэтгэлээр 769,074.8 мянган төгрөгийг зарцуулж батлагдаагүй өөрийн зардлын төлөвлөгөөг 65.8 хувиар буюу 305,356.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна..	344,674.3	Албан шаардлага өгөх	Ажлын албаны захирал, Нягтлан бодогч	Ж.Ариунболд Г.Отгон
	Дүн	344,674.3			

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]